

Маркын бялууны алхалт

Марк аяган булуунд дуртай ч туранхай байх хүсэлтэй. Аяган бялуу бүр илчлэгийн хэмжээтэй бөгөөд илчлэгийг шатаахын тулд Марк алхаж болно. Хэрвээ Марк j аяган бялуу идсэн байгаа бөгөөд C илчлэгтэй аяган бялуу идвэл жингээ барихын тулд хамгийн багадаа $2^j * C$ бээр / мил / алхах шаардлагатай.

Жишээ нь. Хэрвээ тэрээр 3 аяган бялуу идсэн бөгөөд илчлэгийн хэмжээ нь уг дараалалтай **[5,10,7]** байсан бол түүний алхах хэрэгтэй бээрийн хэмжээ нь $(2^0 * 5) + (2^1 * 10) + (2^2 * 7) = 53$. Гэхдээ энэ нь алхах шаардлагатай хамгийн бага зай биш бөгөөд бид бялуу идэх дарааллаа харгалзан үзэх хэрэгтэй.

Хамгийн бага зай нь $(2^0 * 10) + (2^1 * 7) + (2^2 * 5) = 44$ байна.

Бялуу бүрийн илчлэгийн хэмжээ өгөгдсөн бол Марк жингээ барихын тулд хамгийн багадаа хэдэн бээр алхах хэрэгтэйг тооцоолно уу. Бялуунуудыг ямар ч дарааллаар идэж болно.

Функцын тайлбар

marcsCakewalk функцыг гүйцээ.

Буцаах утга long integer төрлийн хамгийн бага **бээрийн** хэмжээ.

Параметер calorie - Бялуунуудын илчлэгийг илэрхийлэх integer төрлийн array

Оролт

Эхний мөрөнд бялууны тоог илэрхийлэх бүхэл тоо n өгөгдөнө.
Хоёр дахь мөрөнд зайгаар тусгаарлагдсан бүхэл тоонууд өгөгдөнө.

Хязгаарлалт

$1 \leq n \leq 40$

$1 \leq c[i] \leq 1000$

Гаралт

Марк жингээ барихын тулд алхах шаардлагатай хамгийн бага зайг илэрхийлэх long integer тоо.

Жишээ оролт 0

3

1 3 2

Жишээ гаралт 0

11

Тайлбар 0

Түүний алхах зайн хэмжээг miles гээ, тэгвэл miles-г хамгийн бага байлгахын тулд 3 аяган бялууг доорхи дарааллаар идье:

- 3 илчлэгтэй булууг эхэлж идье

$$miles = 0 + (3 * 2^0) = 3$$

- 2 илчлэгтэй булууг дараа нь идье

$$miles = 3 + (2 * 2^1) = 7$$

- 1 илчлэгтэй булууг хамгийн сүүлд идье

$$miles = 7 + (1 * 2^2) = 11$$

Тэгээд miles-н утга буюу 11-г буцаана.

Жишээ оролт 1

4

7 4 9 6

Жишээ гаралт 1

79

Тайлбар 1

$$(2^0 * 9) + (2^1 * 7) + (2^2 * 6) + (2^3 * 4) = 9 + 14 + 24 + 32 = 79$$

Орчуулсан : Б.Даваабаяр АНУ